



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/272

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын 2026 оны "Аймгийн 2026 оны төсөвт зохицуулалт хийх тухай" 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд "Бигэр сумд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах ажил"-ыг гүйцэтгэх эрхийг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т олгосугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнан ажиллахыг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т үүрэг болгосугай.

3. Цаашид ашиглалтыг зохих хууль, журмын дагуу хариуцаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т даалгасугай.

4. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



